

ЯРУУ НАЙРГИЙН ЗҮЙРЛЭЛ ТАНИХУЙН ЗҮЙРЛЭЛИЙН НЭГЭН ТӨРӨЛ БОЛОХ  
НЬ (Б.Лхагвасүрэнгийн яруу найргийн жишээгээр)

Н.Нансалмаа<sup>1</sup>

*Товчлол:* XX зууны сүүлээр хэлшинжлэлийн ерөнхий чиг хандлага өөрчлөгдөхийн хамт зүйрлэл судлалд ч шинээр хандах болсон байна. Зүйрлэл судлал хэл судлалд дангаар хамаатай бус, харин хүн судлалын олон салбарыг нэгтгэсэн танихуйн хэлшинжлэлийн судлахуун болжээ.

*Түлхүүр үг:* танихуйн зүйрлэл, яруу найргийн зүйрлэл, Б.Лхагвасүрэн, сэтгэл болох үйл ажиллагаа, соёлын тусгал

1.

Зүйрлэл судлал цаг хугацаа, орон зайн хязгааргүй. Зүйрлэх үзэгдлийн нууцыг тайлахаар эртний герегийн гүн ухаантан Аристотелоос эхлэн Э. Кассирер, Х. Ортеги-и-Тассет, А. Ричарде, Ж. Серль, Р. Якобсон, М. Блэк, Ж. Миллер, А. Вежбицка, Э. МакКормак, Ж. Лакоф Н.Д. Аругионова нарын зэрэг цаг цагийн, улс улсын ухаант мэргэд, эрдэмтэн судлаач, гүн ухаантан, хэл судлаач, сэтгэл судлаач, зохиолч, яруу найрагч, зураач, дэлгэц, тайзны бүтээлийн найруулагчаас гадна энгийн бидэн хүртэл бодлоо чилээж ирсэн ч өнөө хэр энэ үзэгдлийн нарийн учрыг бүрэн гүйцэд тайлаагүй л байна.

Өнгөрсөн энэ урт хугацааны туршид зүйрлэл судлалын салбарт асар их туршлага хуримтлагдаж, уламжлагдаж иржээ. Гэвч зүйрлэл судлалд зөвхөн уламжлал гол үүрэгтэй гэж үзэх нь буруу бөгөөд хүн төрөлхтний мэдлэгийн дээд хэлбэр болох шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд судалгааны чиг хандлага өөрчлөгдөж, зүйрлэл гэх ойлголт ч өөрөө өөрчлөгдөж, зүйрлэх үзэгдлийг тайлбарлахаар улам бүр олон салбар ухаан хамтрах болж хүрээ нь тэлж ирсэн нь зүй ёсны хэрэг юм.

Хураангуйлж үзвэл зүйрлэлийг эхэн үедээ уран илтгэх урлагийн нэгэн хүчтэй хэрэглүүр, хэл яриаг чимэх, бусдыг итгүүлэх зэмсэг, уран сайхны арга гэж үзэж байсан бол хожим нь зүйрлэлийг хэлний үзэгдэл болох үүднээс судлах болсон байна. Зүйрлэл судлалын дараагийн алхам нь түүнийг утгазүйн үүднээс судлах явдал болсон бол 20-р зууны сүүл үеэс эхлэн танихуйн шинжлэх ухааны хүрээнд зүйрлэл судлалын шинэ үе эхэлсэн билээ.

Судлаачдын ихэнх нь зүйрлэл үгийн шилжсэн утгатай холбоотой хэлний хэрэглүүр, нэг юмны нэрийг нөгөө зүйлд аль нэг адил төстэй шинжийг харгалзан шилжүүлэх явдал гэж үздэг. Монгол, орос хэлний зүйрлэлийн хэрэглээний баримтаас үзэхэд үнэн хэрэгтээ зүйрлэл юм, үзэгдлийн үнэхээр байх адил төстэй аль нэг шинжийг олж харж хэрэглэхээс гадна өгүүлэгч, эсвэл бичигч зүйрлэлийг шинээр бүтээдэг. Өөрөөр хэлбэл, өгүүлэгч этгээд заримдаа үгийг

1. Монгол Улсын Их Сургууль

урьд өмнө хэн ч хэрэглэж байгаагүй, бүр өөрөө ч хэрэглэж байгаагүй тийм ер бусын утгаар хэрэглэн зүйрлэл бүтээх тохиолдол ч бий (энэ тухай Н.Нансалмаа, 1997, дэлгэрэнгүй үзнэ үү). Ийм мэт тохиолдлын шинж нь хувь хүний танихуй, сэтгэлгээний онцлог, улмаар хэрэглээтэй холбоотой. ХХ зууны сүүлээр хэлшинжлэлд хүн төвтэй хандлага бий болсноор зүйрлэл зөвхөн цэвэр хэлний баримт бус мөн хүний оюун ухаан, дотоод сэтгэл, танихуй, сэтгэн бодох үйл ажиллагаатай холбоотой нарийн үзэгдэл болох талаас судлаачдын сонирхлыг татах болоод байна. Энэ тухайд оросын эрдэмтэн Н. Д. Артюнова “Зүйрлэлийг сэтгэхүй, ертөнцийн үндэсний зураглал болон түүний нийтлэг дүрийг илэрхийлэх үйл явц болох талаас хандах болжээ” – гэж дүгнэсэн нь бий (Артюнова, 1990, 5).

Зүйрлэлийн танихуйн шинэ онол Э. МакКормакийн “Зүйрлэлийн танихуйн онол” бүтээлд тусгалаа олжээ. Тэрээр уг бүтээлдээ зүйрлэлийг танихуйн үйл явц гэж тодорхойлсон байна. “Зүйрлэлийг танихуйн үйл явц болох талаас тайлбарлахын тулд хүний оюуны гүн бүтцийг хэл үүсэж бий болох төхөөрөмж хэмээн үзэх нь зүйтэй” (Э. МакКормак, 1990, 359).

Түүнтэй ижил санааг бид дараах ишлэлээс олж харах боломжтой. Нью-Йоркийн Их сургуулийн профессор, Танихуйн сэтгэл судлал ба танихуйн үйл явцын судалгааны хүрээлэнгийн захирал Элхонон Гольдберг: “Тархи хүний биед болж буй биезүйн янз бүрийн үйл явц болон ухамсар, сурах, өөрийгөө хөгжүүлэх чадварыг хянаж байдаг. Тархи хэл яриатай холбоотой төдийгүй хөдөлгөөн, аливааг хүлээж авах чадвар, ой санамж, хүсэл зориг, түүнчлэн аливаад дурлах, биеэ тоох, шийдвэр гаргах, хийсэн үйлдлийнхээ үр дагаварыг урьдчилан таамаглах, өөрийгөө дүгнэх, нийгмийн хэм хэмжээг сахих зэрэг хувь хүнийг тодорхойлох шинжүүдийг хариуцна”- гэжээ (Гольдберг, 2003).

Тархи, ухамсар, хэл салшгүй холбоотой болох тухай дээрх санааг миний бие “тиймээ” хэмээн бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм. Танихуйн ухааны нэг бие даасан салбар ухаан болох танихуйн хэлшинжлэл ухамсар буюу хүний бодилог биед эсрэгцэх хийсвэр дотоод, сэтгэлийн талыг хэлний баримтаар судална. Танихуйн хэлшинжлэл танихуйн үйл явцыг судалж, хүний ухамсарт орших бодит ертөнцийн сэтгэлгээний тусгалыг хэлшинжлэлийн аргаар судалж, үүний дараа танихуйн тайлбар хийн дүгнэлт гаргадаг (Нансалмаа, 2012, 42-54).

Танихуйн хэл шинжээч Ж. Лакоф, М. Жонсон нарын үзэж буйгаар зүйрлэл бидний өдөр тутмын амьдралд нэвтрэн орж зөвхөн хэлээр төдийгүй мөн сэтгэхүй, үйлдлээр илэрнэ. “Бидний сэтгэж, үйлдэл хийдэг ухагдахууны тогтолцоо өөрөө зүйрлэлийн шинжтэй”- хэмээн тэд баталж байгаа билээ (Лакоф, Жонсон, 1990, 388).

• Зүйрлэх үзэгдэл ингэж үзвэл дан ганц хэлэнд хамаатай бус. Зүйрлэх үзэгдэл сэтгэн болох үйл ажиллагаатай холбоотой, аливаа юм үзэгдлийг шинээр таниж мэдэхдээ хүн урьд өмнө өөрийн хэдийнээ мэдэх юм, үзэгдэл, ухагдахуун, ойлголттой жишин харьцуулж адил төстэй талыг олж харан, эсвэл ургуулан бодож шинээр зүйрлэл үүсгэнэ. Ингэхээр зүйрлэл бол хүний ганин мэдэх, сэтгэн бодох үндсэн арга. Танихуйн үйл ажиллагаа бүтээлч үйл ажиллагаа. Энэ үйл ажиллагаа хүний хүчин зүйлээс шууд хамааралтай. Хүний хүчин зүйл гэхдээ миний хувьд зүйрлэл бүтээгч хүний ертөнцийг үзэх үзэл, хандлага, бодит ертөнцийг таньсан амьдралын туршлагыг онцолж буй гэдгээ тэмдэглэе. Түүнээс гадна зүйрлэл бүтээх хувь хүний бүтээлч үйл ажиллагааны салшгүй нэгэн суурь нь ард түмний соёлын хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл, зүйрлэл ард түмний соёлын илэрхийлэл болно.

Нөгөө талаас зүйрлэлийг тархины зүүн, баруун бөмбөлгийн үйл ажиллагаатай холбон үзэх нь зүйтэй. Тархины зүүн, баруун бөмбөлгийн үүргийн тэнцүү бус чанарыг Марк Дакс (1836), Л.Виган (1844), Х. Жексон (1868) нар тэмдэглэж байсан ба америкийн судлаач Р. Сперри тархины бөмбөлгийн үүргийн ийм тэнцүү бус чанарыг нээснийхээ төлөө 1981 онд Нобелийн шагнал хүртсэн байна. Р. Сперри болон түүний багийнхан тархины хоёр бөмбөлгийн ялгаа, үүнтэй холбоотойгоор сэтгэхүйн танихуйн хэв шинжийн ялгаа нь мэдээлэл боловсруулах арга, сэтгэн бодох үйл явцад мэдрэлийн эсэд гол нөлөө үзүүлдэг гадаад, дотоод орчны өөрчлөлтийн

холбоог зохион байгуулах зарчмуудаас хамаарна гэж үзсэн байна (Нансалмаа, 2012, 44). Уран сайхны мэдрэмж, дүрслэл, мөрөөдөл, төсөөлөл, уран сэтгэмж, хийсвэрлэх, үгчилсэн бус шилжсэн утга ойлгох үүрэг бүхий тархины баруун бөмбөлөг зүйрлэл үүсэх, ойлгоход голлох үүрэгтэй.

Э. МакКормак зүйрлэлийн 1. Өнгөн түвшин – Соёл, 2. Гүн түвшин - Утгазүй ба өгүүлбэрзүй, 3. Хамгийн гүн түвшин - Танихуй гэсэн гурван түвшинг ялган үзэж эдгээр түвшин танихуйн үйл явцыг ойлгоход туслах эрэл хайгуулын механизм болно гэсэн байна. Эл судлаач зүйрлэл бол тархи, оюун ухаан, соёлыг хэлний бүтээлч үйл ажиллагаанд нэгтгэсэн танихуйн хувьсах үйл явц юм гээд “учир зүйг дотор талаас хайвал зүйрлэл ертөнцийн тухай бидний төсөөллийг гүнзгийрүүлэх танихуйн үйл явц болох бол гадна талаас хайвал зүйрлэл хүний оюун ухаан болон соёлыг холбогч болно” - гэжээ (Э. МакКормак, 1990, 359). Эндээс үзэхэд аливаа зүйрлэл ард түмний, хувь хүний соёл, танихуйн үйл ажиллагааны тусгал болох бөгөөд эдгээр нь хүний сэтгэн бодох нарийн үйл ажиллагааны үр дүн болж эргээд хэлээр илэрнэ.

Түүний санал болгож буй гурван түвшинг дараах байдлаар хялбарчлан ойлгож болох юм. Танихуй утгыг тодорхойлно. Энэ байдал хэлээр илэрнэ. Хэн нэгний бүтээлч байдлаар үүсгэсэн зүйрлэл хэлийг өөрчилнө.

Хүрээний (фрейм) онолыг үндэслэгч Минский: “хангалттай боловсролтой хүн бүр ус - цахилгаан, яруу найраг – хөгжим гэх мэт гишүүд нь огт өөр, адилгүй томоохон хүрээнүүдийн тогтолцоотой. Ийм адил байдал тэдгээрийг хэрэглэх чадварын нэг адил сэтгэхүйн хамгийн хүчирхэг зэмсгийн нэг юм. Эдгээр адил байдал бидэнд аль нэг юм, эсвэл санааг өөр юм, эсвэл санааны “сувгаар” харж, ингэснээр нэг салбарт олж авсан мэдлэг, туршлагаа өөр салбарын асуудлыг шийдэхдээ хэрэглэх боломж олгодог. Чухам ингэж шинжлэх ухааны нэг чиг хандлагын мэдлэг нөгөөд түгдэг (Минский, 1988, 291- 292) гэсэн нь хүн бид цогц ойлголтоор сэтгэдэг гэх суурь санааг илэрхийлж байгаа юм. Ер нь энэ цогц ойлголтоор сэтгэдэг гэх санаа танихуйчдын бүтээлд өргөн туссан байдаг. Бидний шинжлэх гэж буй яруу найрагч Б. Жахгвасүрэнгийн шүлэгт *заимны товч- нулимс* (Хүүдээ унших шүлэг), *шүлэг - хүн чулуу* (Боржигины бор тал), *хацар – жимс* (Аргаа барсан шүлэг), *уруул - хоёр мор шүлэг* (Тэр нэгэн бүсгүйд), *Би - билүүний хэлтэрхий* (Би) гэх мэтээр бодит байдлын өөр өөр хүрээнд харьяалагдах юм, үзэгдэл ухагдахуунд хандаж тэдгээрээс адил, төстэй шинж олж харж нэгнийх нь шинжийг нөгөөд шингээн зүйрлэл үүсгэсэн нь Минскийн дээрх санааг багалж буй хэрэг юм. Хүн зүйрлэлээр сэтгэдэг гэсэн санааг зүйрлэл бүтээх тал дээр бид зөвшөөрсний дараа зүйрлэлийг ойлгоход ч мөн танихуйн үүрэг чухал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Зүйрлэл гэх нэртомьёог бид тодорхой нөхцөл байдал, орчин эсвэл тодорхой бичвэрт үгээр илэрч байгаа хоёр бүрдүүлбэртэй сэтгэхүйн нэгж гэж ойлгох учиртай. Энэ хоёр бүрдүүлбэр хоёул хүн бидний бодит амьдралд буй хоёр тусдаа багц мэдлэг, цогц ойлголт буюу концепт. Энэ хоёр цогц ойлголтын аль нэг холбоос дээр зүйрлэл үүснэ. Ингэхдээ аль нэг тодорхой хэлээр хэлэлцэгч ард түмний ертөнцийн тухай төсөөлөл, үзэл баримтлал, үнэ цэнийн тухай ойлголт зүйрлэлд туссанаар хэлээр хэлбэржинэ.

2.

Зүйрлэл бол сэтгэх, соёл илэрхийлэх арга болох тухай орчин үеийн чиг хандлагыг хүлээн зөвшөөрсний дараа бид яруу найргийн зүйрлэл танихуйн зүйрлэлийн нэгэн төрөл гэсэн гол санаагаа гаргахад бэлэн боллоо гэж үзэж болох юм.

Яруу найргийн зүйрлэлийг хэлний уран яруу хэрэглүүр болохын хувьд, мөн яруу найргийн үүрэг талаас судлан ерөнхий хэлшинжлэл арвин туршлага хуримтлуулжээ. Гэвч Э. МакКормак нэгэнтээ тэмдэглэснээр яруу найргийн зүйрлэлийг танихуйн зэмсэг гэж үзэж байсангүй. Тэгвэл дөнгөж сая бидний авч үзсэнээр зүйрлэл бүтээхэд ч, зүйрлэл ойлгоход ч танихуйн үйл ажиллагаа чухал үүрэгтэй байна. Мөн танихуйн хэлшинжлэлийн гол цөм ойлголт нь ХҮН. Танихуйн зүйрлэл бол хүн төвтэй, хүнд суурилсан зүйрлэл юм. Танихуйн яруу найргийн зүйрлэлд нэг

талаас, найрагчийн сэтгэн бодох, дүр бүтээх, нөгөө талаас, уншигчийн уг дүрийг танихын тулд сэтгэн бодох чадвар чухал. Эндээс үзэхэд зүйрлэлд сэтгэн бодох, хийсвэрлэх чадвар чухал. Энэ санааг дэлгэрүүлэхийн тулд өнөөдөр танихуйчдын батлах болсон хүн концептоор сэтгэдэг гэсэн санааг дэмжин зүйрлэлд нэг зүйлийг нөгөөтэй адилтган зүйрлэх нь аль нэг үгийг нөгөө үгтэй харьцуулж байгаа хэрэг биш, харин нэг концептыг нөгөөтэй бүхэлд нь харьцуулан сэтгэж байгаа гэдгийг анхаарах нь чухал. Харин харилцааны явцад сэтгэлгээ хэлний нэгжээр илэрнэ. Бидний тархинд, оюун санаанд буй бодит ертөнцийн тусгал бол толин тусгал биш. Хүн сэтгэхдээ бодит ертөнцийг өөрийнхөөрөө харж, тусгаж, хүлээж авдаг. Ингэж харж тусгаж авах үндсэн арга нь зүйрлэлээр сэтгэх бөгөөд өөрийн амьдарч буй ертөнцийг зүйрлэлээр дамжуулан таньдаг. Чухам энэ сүүлийн санаа өнөөдөр танихуйчдын хүлээн зөвшөөрдөг санаа юм. Хэн ертөнцийг ямар байдлаар харж чадаж байна, ертөнц түүний хувьд тийм л байна.

Чухам энэ байдлыг харгалзан хэл шинжээчид “ертөнцийн хэлний зураглал” хэмээх ойлголтын тухай ярихдаа хүн төрөлхтний нийтлэг зураглал, ард түмний үндэсний зураглал, хувь хүний зураглал гэж ангилан үздэг билээ. Хувь хүний зураглал нь “хүн төрөлхтний нийтлэг зураглал”, “ард түмний үндэсний зураглал” гэх бүтэцтэйгээс гадна зөвхөн түүний өөрийн танихуйн туршлагын тусгалыг ч мөн агуулна. Сүүлийн энэ бүрдүүлбэр давтагдашгүй онцгой шинжтэй. Энэ гурван зүйлийн ертөнцийн зураглалын нийлбэр хэлний тодорхой хамт олны төлөөлөгч болох хувь хүний танихуйн үйл ажиллагааны үр дүнд түүний тархинд аль нэг хувилбараар оршино. Бидний жишээ болгон авч буй агуу найрагч Б. Лхагвасүрэнгийн **шүлэг найраг нь гэрээр ертөнцийг хэрхэн харж буйн тусгал мөн**. Энд өгүүлэгч миний бие түүний ертөнцийг үзэх үзэл, найргийг мөн л өөрийнхөөрөө ухааран ойлгож авч буй бөгөөд өөр хэн нэгэн огт өөрөөр ухаарч хүлээж авахыг огтхон ч үгүйсгэж аргагүй. Найрагчийн ертөнц түүний шүлгийн хэлээр илэрч байгаа бол уншигч энэ ертөнцийг хэрхэн хүлээж авч ойлгож байгаа нь мөн л түүний танихуйн туршлага, дотоод ертөнцөөс хамаарна.

3.

Дээр өгүүлсэн бүхнээс үүдэн яруу найргийн зүйрлэл танихуйн зүйрлэлийн нэг төрөл юм гэдгийг харуулахын тулд Монголын орчин үеийн яруу найргийн нэрт төлөөлөгч Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн яруу найргийн зүйрлэлд ажиглалт хийхээр зориглосон билээ.

Ш.Балли: “бид хийсвэр ухагдахууныг мэдрэмжийн ертөнцийн юмтай адилтгадаг. Учир нь ингэх нь бидний хувьд тэдгээрийг танин мэдэх, бусдад таниулах цорын ганц арга юм. •Зүйрлэлийн үүсэл гарал ийм; зүйрлэл бол хийсвэр ойлголтыг тодорхой юмтай ойртуулах хандлагын нөлөөгөөр оюун ухаан тэдгээрийг нэг үгэнд нэгтгэдэг харьцуулалтаас өөр юу ч биш” –гэж бичиж байжээ (Балли, 1961, 221).

Шүлэг яруу найраг зөвхөн мэдээлэл дамжуулаад зогсохгүй, найрагчийн бодол санаан дахь ертөнцийн түмэн зүйлийн холбоо хэлхээг шинэ дүрд амилуулж юм, үзэгдэл ухагдахууныг цоо шинээр харж шинэ шинэ дүр, дүрслэл бүтээдэг. Ер нь зүйрлэлд хам бичвэр, эсвэл хам орчин асар их үүрэгтэй, өөрийн гэсэн онцлогтой. Хэрэв үргэлжилсэн үгийн зохиолд зүйрлэл багахан хэмжээний тодорхой хам бичвэрт ойлгомжтой байх боломжтой, тэр бүр зүйрлэл ар араасаа үргэлжилсэн давтамжтай байдаггүй бол шүлэг яруу найрагт зүйрлэл ар араасаа үргэлжлэн уран яруу дүрслэл, уянгалаг хөг аясын гинжин хэлхээ үүсгэнэ. Яруу найрагч ертөнцийг бусдаас өөрөөр харж, өөрөөр сэтгэж үгийн бусдад танил ерийн хэрэглээг огт санаандгүй байдлаар зөрчдөг. Түүний шүлэгт зүйрлэл шинээр төрж, шинэ хэрэглээ бий болгоно. Хэлсэн зүйлийн жишээ болгож Б.Лхагвасүрэнгийн “Би” шүлгийн зүйрлэлд анхаарлаа хандуулъя.

Шүлэг яруу найраг тэр чигээрээ зүйрлэл байх нь бий. Тэгвэл энэхүү шүлэг ч сая хэлсэн зүйлийн тод жишээ юм.

**Би - нэмэгдэхүүн**

**Би - газар, тэнгэрийн хүү**

*Би - Дуртгал маргааш хоёрын хэлхээ*

*Би -Дуу нулимс хоёрын голтриг*

*Би -Хоёр туйлыг холбосон уртраг*

*Би -Төрөх үхэхийн дундах бодгаль*

*Би -Гэрэл сүүдрийн цогц*

*Би - билүүний хэлтэрхий*

*Би -Дороо эргэлдэх өдөр шөнө*

*Би - Газрын хаан*

*Би - хасагдахуун*

Тэрээр төрөхөөс (нэмэгдэхүүн) үхэх (хасагдахуун) хүртэлх амьдралын утга учрыг дээрх байдлаар зүйрлэсэн байна. Шүлэгт гарч буй зүйрлэлийн нэг тал БИ буюу найрагч өөрөө, түүний ертөнц, нөгөө тал нь газар, тэнгэрийн хүү болж өнгөрсөн ирээдүйг холбон төрсөн шинэ хүн нэмэгдэхүүн болж, амьдралын жаргал зовлон, сайн муугийн хоёр туйлыг ээлжлэн туулж амьдрах ухаан, туршлага суун чамбайрч энэ бүхнээ сэтгэл харамгүй бусдад өвлүүлэн бусдыг ирлэн өөрөө элэгдэж эцэст нь хасагдахуун болох хүмүүний амьдралын жам ёс юм. Эдгээр зүйрлэл бүр түүний амьдралыг үзэх үзэл, сэтгэлийн нарийн хөгийг илэрхийлж тэр бүр жирийн хүн олж харахааргүй оновчтой, ер бусын болжээ. Чухам ийм ер бусын байдлаараа бусдын сэтгэлийг хөдөлгөж “нээрээ тийм дээ” хэмээн толгой дохиж хамар шархирмаар.

Зүйрлэл, тэр дундаа яруу найргийн зүйрлэлд зүйрлэлийн А ба Б хоёр талыг адил гэж батлах нь тэр бүр үнэнтэй нийцдэггүй. Олонх тохиолдолд энэ нь огт худал, боломжгүй зүйрлэл (А тал: *Би – Б тал: нэмэгдэхүүн, газар, тэнгэрийн хүү, Дуртгал маргааш хоёрын хэлхээ, Дуу нулимс хоёрын голтриг, Хоёр туйлыг холбосон уртраг, Төрөх үхэхийн дундах бодгаль, Гэрэл сүүдрийн цогц, билүүний хэлтэрхий, дороо эргэлдэх өдөр шөнө, Газрын хаан, хасагдахуун*) байх ч чухамдаа энэхүү хэтрүүлэл яруу найргийн зүйрлэлийг яруу сайхан уянгалаг болгох гол онцлогийн нэг юм. . . . .

Эдгээр шууд зүйрлэлээс гадна

*Ижийг минь төрөх гээд ёолоход*

*Зуун цэцгийн дэлбээ тасарсан ч*

*Намайг төрөөд чарлахад*

*Мянган цэцэг цомирлогоо дэлгэжээ*

эхний дөрвөн мөрт *төрөх гээд ёолох – төрөөд чарлах, цэцгийн дэлбээ тасрах - цэцэг цомирлогоо дэлгэх, зуун цэцэг - мянган цэцэг* гэх эсрэгцлүүд байгаа нь мөн л зүйрлэл үүсгэжээ. Найрагч Хүн хорвоод мэндэлж нэгэн бие хоёр болон салах тэр мөчид цэцгийн дэлбээ тасарч, хүүхэд –хүн цэцэг төрөөд чарлахад цэцэг ч мөн баясан цомирлогоо дэлгэнэ гэсэн нь амьд байгалийн холбоо, шинэ амьдралын баяр гэсэн санаа хэмээн зүйрлэсэн болов уу.

Бавуугийн Лхагвасүрэн найрагчийн “Ижий мөрөн” шүлэгт ч мөн ийм зүйрлэлийн хэлхээ байх юм. Шүлгийн “Ижий мөрөн” нэр ч мөн л зүйрлэл, амьдрал тэтгэж, амьдрал хайрладаг “эхийн сүү”, “Ижий”, “мөрөн” гэх хоёр тусдаа, ердийн амьдралд нийлэмж үүсгэх боломжгүй хоёр үг харин энэ шүлэгт цоо шинэ нийлэмж үүсгэн хамтдаа утга төгс санаа илэрхийлжээ.

Эхийн сүүг яруу найрагч:

*Зөөлөн буурал газрын шим*

*Зөн хүслийн халуун амь*

*Холын далайн гашуун шорвог*

*Хоёр туйлаас уурисан ус*

*Өнгө нь хувилсан цус*

*Өөрийгөө мартсан “Тус”*

*Инээд нулимс*

*Их аз жаргалын амт*

*Шимэн шимэхэд зангираагүй*

**Шингэн "Алт"**

*Хэн болох нь хамаагүй*

*Хүн бүхний ам руу орсон*

*Бие бүхэнд оришиж*

*Битүү гогцоо татаж*

*Наран зөв эргэсэн*

**Нас манасан урсгал**

*Ангаахай нялх үрийнхээ*

*Амыг эрэн чинэж*

*Аян дайнд эндэхэд*

*Арьсан цаана ээдэж*

**Агуу ухааны**

**Дархан байж**

*Алдаж оноход*

**Дарь - Эх байж**

*Гурван цагийг нэвт урссан*

*Гунигийн сүүдрийг сүлж урссан*

**Ижий мөрөн**

*Энэ дэлхийн мөрөн далай болгон*

*Ижий мөрнөөс урссан тасархай*

*Энэ дэлхийн хүн болгон*

**Ижий мөрний алтан жаргахай** хэмээн бодит ба хийсвэр ухагдахууны эрс тэс ялгаатай олон юм, үзэгдэл, ойлголттой хийсвэрлэн зүйрлэсэн байх юм.

Үхэл ирэхээс өрсөж Дэлгэр Монголоо дуулж яваа найрагч шүлэг найрагтаа эх нутгийнхаа дүрийг дараах байдлаар уран яруу зүйрлэн дүрсэлсэн байна: **Тал - тэнгэрийн хэвтэр, нар хур царайчилсан газрын саальтай хормой, булаг - газрын нүд, алсын намхан уулсын орой - хөрөөний ир, уулсын үрчгэр бэл - Өвгөд, манхны хээ - Үелэн шаргалтах нарны хайлш (Өргөдөл), нойтон нуга- хүүхдийн зулай, цэнхэр зэрэглээ- бэлчээрт гээсэн алчуур** (Миний түүх).

Б.Лхагвасүрэнгийн шүлэг найрагт хүнийг дүрсэлсэн зүйрлэл түүний нас, үзэж туулсан амьдралыг эх нутаг, уул ус, байгал орчин, монгол ахуйтайгаа зүйрлэж **нас өндөр болсон аав ээж хоёр** - *аргиж хатсан хоёр хайлаас* (Аргаа барсан шүлэг) **өвөө** - *Түрхрэн эргэх цусны цөм, Хөх талын бүргэд, усанд элсэн чулуу, Билүүдсэн хутга, Насыг элээсэн цагийн хэлхээ* (Миний өвөг эцгийн түүх), **эцэг**- *Үлгэрт гардаг "нусгай бор", Ураг улаан галын тэнгэр, Уул талын "Морьтой" дуу, Эргээн хэлбэсэн ус, Элж бууралтсан уулс, морьтой "хариацай", Эгнэсэн жагсаалын шинельтэй амь, Эгэл түмнийхээ итгэлийн манаа, Хосоороо болж ганганасан Хонгорын бүрдийн ангир, Учир нарийн амьдралын Ураг алтан хэлхээ Уламж хойч хоёрын Удам залгасан холбоо Хотойж ер үзээгүй Он жилүүдийн хүн гүүр* (Миний эцгийн түүх), **ээж** - *Хагицлаар чулуужсан аялгуу Халуунаараа царцсан сүү (Ээжээ), Дэлхийд намайг тулсан Цагаан тэнхлэг* (Буруу энгэртэй дээл) гэх зүйрлэлүүд бүтээсэн бол "Би бол үүсгэгчээ үгүйсгэсээр өндийсөн үгүйсгэгч бодьгал юм" - гэж үздэг яруу найрагчийн шүлэгт **Би** - *Цаг тооны үргэлжлэл, Цагаан сүүний ургамал, Алга, алга дамжсан "Амьсгалдаг тоглоом"* (Миний түүх), **Ижий минь би таны Үргэлжлэл** (Ээжээ), **Би жаргалд боолттой зовлон Би гэрэлд боолттой харинхуй Дуунд чинь аргамжаатай Дутуу заяа** (Харанхуй), **Солонго** (Солонго билээ би), **Салхи хөглөж эгээрсэн Эмээлийн дууны эзэн, Үзэл бодлын дайчин хорооны Жагсаалын цэрэг** (Өргөдөл), **Чи билэн хоёр:** *Хөх тэнгэрийг мөрлөн өндийсөн Хос багана, Эвлэж уулзсан таван хананы Эхлэл төгсгөл, Үрийн заяаг мялаах хаалганы Өлзий утас, Илчээ соёрхох ган тулганы Ихэр дөл* гэх

мэтээр буужээ.

Эдгээр бүх зүйрлэлийн хоёр тал тус тусдаа бие даасан гүн гүнзгий утга агуулгатай, байнгын ба хувьсах олон шинж хувилбартай, өөр бусад хам бичвэр, хам орчинд өөр талаараа илрэх боломжтой бие даасан концепт буюу цогц ойлголт, багц мэдлэг юм. Зүйрлэл бүр энэ хоёр тусдаа цогц ойлголтын олон талт суурь мэдлэг, шинж байдал, үйлдлийг зүйрлэл бүтээгч хүн бүтээлчээр ажиглан нэгтгэсний үр дүн.

Жинхэнэ нэрээр зүйрлэл илрэхээс гадна амьд ба амьгүй ертөнцийн юм үзэгдлийг хүншүүлж, амьдшуулж, мөн эсрэгээр юмжуулж зүйрлэлийн хоёр бүрдүүлбэр хоёул нөгөө бүрдүүлбэрийнхээ шинж байдлыг хэсэгчлэн, эсвэл тэр чигээр нь бүрэн шилжүүлэн авч хийдэг үйл, үйлдлийг нь ч хийдэг байна. Тухайлбал, *Цас ёолно, Хад улина, Хорвоогийн хормой чичирнэ, "Цагаан ороолон"* (цасан шуурга) маналзана, наран над дээр л асгарна, Аараг толгодын элс алтаар нурина, зэрэглээ хормойтой орооцолдоно, зэрэглээ хөлийн сайр долооно, Сүү нөмөрч унтана (Ижийтэйгээ байхад), найрагч бэхэнд нялхарна (Өргөдөл), од салхи хөлөглөнө, Боржигины бор тал ботго нь үхсэн ингэний цусны туяатай сүүг залгиж зовлонг нь хугаслана, талын шарх зүрхний шархнаас хождож анина (Боржигины бор тал), Ухаант ардын дуу хүнийг хүлнэ (Хуримын зар), хүн сагсайтал цэцэглэнэ (Аргаа барсан шүлэг). Мөн түүнчлэн "Миний өвөг эцгийн түүх"-эд одор, өдрийг "хонь шиг холбож" Өнгөрөх мөчийг "хурга шиг хөгнөж", Өнөөгийн зууны босго дэрлэж унасан Үдшийн гэгээг морьтойгоо аргамжиж Үүртэй золгуулсан гэрлийн илч, Билгийн дөрвөн улирал дунд усны чулуу шиг элж Билүүдсэн хутга шиг ирлэгдэж ирсэн өвөг эцэг гэх мэтээр дээрх жагсаалт үргэлжилнэ.

Яруу найрагт зүйрлэл дээр өгүүлсэн шиг зохиогчийн ертөнцийг үзэх үзэл, дотоод сэтгэлийн илрэл болохоос гадна "дүр, дүрслэл" үүсгэх маш чухал нэгэн онцлогтой. Зүйрлэл найрагчийн танихуйн тусгал болохдоо зүгээр нэг мэдээлэл дамжуулаад зогсохгүй, уншигчид дасал болоогүй ер бусын байдлаар юм, үзэгдлийн хооронд холбоо үүсгэж, харьцуулж тэдгээрийг шинээр харах, ухааж ойлгох, хүлээж авах боломж бүрдүүлдэг. Ийм боломж бодог юм, эсвэл хийгвэр ойлголтыг зүгээр ч нэг харьцуулж байгаа хэрэг биш, харин тэдгээрийн дүр, дүрслэл хамтран нэгдэж ухамсарт бууж байгаа хэрэг. Энэ дүр хэлний хамт олны дунд танил болсон, бүгд хүлээн зөвшөөрсөн дүр байж болох ч олонх тохиолдолд яруу найргийн зүйрлэл зохиогчтой холбоотой хувь хүний хүчин зүйл давамгайлсан байна.

Б. Лхагвасүрэн найрагчийн шүлэг ч энэ байдлыг батлах жишээ баримтаар асар арвин. Зарим жишээнд анхаарлаа хандуулъя. Түүний шүлэгт байгаа *Чононд хөөгдсөн цавьдар адуу шиг үүлс* гэх зүйрлэлд нэг талаас адуу, нөгөө талаас үүлс байх боловч адууг тодотгосон *Чононд хөөгдсөн цавьдар* гэх тодотгол тэнгэрт хөвөх үүлсийн тодотгол болж улмаар нэгдэн бидний ухамсарт үүлсийн хурд, өнгийг жирийн үгээр илэрхийлснээс илүү үр дүнтэй, уран сайхны дүр, дүрслэл бууж байгаа юм. Үүлсийн ийм дүр байдлыг өөр ард түмний төлөөлөгч - яруу найрагч *чононд хөөгдсөн цавьдар адуутай* зүйрлэх нь юу л бол. Тэрээр өөрийн ард түмний соёлд хүн болсныхоо хэргийг гаргаж дээрхээс өөр зүйрлэл сонгох нь ойлгомжтой. Энэ байдлаас нэг зүйрлэл өөртөө ард түмний амьдрах орчин, ахуйн онцлог буюу өргөн утгаар соёл, сэтгэлгээний үр дүнгээс гадна энэ ард түмний нэг болох хувь хүн, бидний тохиолдолд яруу найрагчийн сэтгэхүй, танихуй, ард түмнийхээ соёлыг таньсан байдал, амьдралын туршлага, ертөнцийг үзэх үзэл зэрэг асар өргөн хүрээтэй олон талт ойлголтыг багтаасан тэдгээрийн үгэн илрэл юм. Ийм маягийн тайлбарыг бид түүний шүлгийн

*Аргиж хатсан хоёр хайлаасны сүүдэр дор*

*Архины шилээр тоглож суугаа үр минь (Аргаа барсан шүлэг)*

гэсэн хоёр мөрт бас хийх боломжтой. Найрагч хүн – хайлаас гэсэн хоёр тусдаа ойлголтыг зэрэгцүүлэн авч зүйрлэл үүсгэх үндэслэл болгосон бөгөөд эцэг, эх - хүүхэд, хүүхэд – тоглоом гэсэн учир шалтгааны холбоонд суурилан *насан өндөр болсон эцэг эх хоёр - аргиж хатсан хоёр хайлаас, модны сүүдэр - эцэг эхийн нөмөрт, хажууд, бийд, үр хүүхэд нь архи уух – архины*

шилээр “тоглох” гэсэн дарааллаар зүйрлэл үүсгэжээ.

Бидний ажиглалт хийсэн яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэнгийн эдгээр болон бусад шүлгийн зүйрлэл хүн төрөлхтний нийтлэг болон монгол түмний ахуй, соёлын тусгал болж бүрэлдэн тогтсон үндэсний сэтгэлгээний онцлог болохоос гадна хувь хүн – найрагч ертөнцийг таньсан хэлний баримт болж байна.

Өнөө цагийн гүн сэтгэгч, “Хүний аливаа дурьдаггал сэтгэл зүрх, оюун тархинаас эхэлдэг” гэж үздэг, “Бор талынхаа хялганын толгой сэвэлзэх Бодол, ухаарлын шүлэг бичвээс Миний хариулах ач тэр” гэж дуу алдсан Бавуугийн Лхагвасүрэн найрагчийн танихуйн ертөнцөд түүний шүлэг найргийн хэлээр дамжин нэвтрэх оролдлого хийсэн минь энэ бөлгөө. Түүний шүлэг, найргийн зүйрлэл нь “зүйрлэл ертөнцийн юм, үзэгдэл, ухагдахууныг таних, багцлах, тайлбарлах, үнэлэмж өгөх сэтгэн бодох арга” хэмээн үздэг өнөө цагийн танихуйн хэлшинжлэлийн судлахуун болохын учир энэ буюу.

### НОМЗҮЙ

*Арутюнова Н.Д.* Метафора // Лингвистический энциклопедический словарь. - М., 1990. - с. 296-297.

*Арутюнова Н.Д.* Метафора и дискурс // Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 5-33

*Блэк М.* Метафора // Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 153-173

*Вежбицкая А.* Сравнение - градация - метафора // Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 133-153

*Голдберг Э.* Управляющий мозг: Лобные доли, лидерство и цивилизация / Пер. с англ. Д. Бугакова. — М.: Смысл, 2003. — 335 с.

*Дэвидсон Д.* Что означают метафоры// Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 173-194

*Кассирер Э.* Сила метафоры//Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 33-44

*Ортега-и-Гассет Х.* Две великие метафоры // Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 68-82

*Лакофф Дж. Джонсон М.* Метафоры, которыми мы живем// Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 387-416

*МакКормак Э.* Когнитивная теория метафоры// Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 358-387

*Минский М.* Остроумие и логика когнитивного бессознательного. — В сб.: Новое в зарубежной лингвистике, вып. XXIII, 1988, с. 281-310

*Нансалмаа Н.* Орос, монгол хэлний амьтны нэрийн хүншсэн утгыг утгазүй, тользүйн хүрээнд судлах нь. Хэл шинжлэлийн ухааны дэд докторын зэрэг горилсон зохиол. УБ. 1997

*Нансалмаа Н.* Хэвлэл мэдээллийн хэлний улстөржсөн зүйрлэл //МУИС. ГХСС. ЭШБ. 2010 № 333 (10) х.39-45

*Нансалмаа Н.* Тархи, Ухамсар, Хэл //МУИС. ГХСС. ЭШБ. 2012 № 363 (16) х.42- 54

*Ричардс А.* Философия риторики //Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 44-68

*Серль Дж.* Метафора// Теория метафоры М.: Прогресс, 1990. с. 307-342

*Ченки А.* Семантика в когнитивной лингвистике //Современная американская лингвистика: фундаментальные направления. Изд. 4-ое, 2010, с. 340 – 366

### СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

Лхагвасүрэн Б. : Аргаа барсан шүлэг, Өргөдөл, Миний түүх, Ээжээ, Миний түүх, Харанхуй, Солонго билээ би, Өргөдөл, Ижийтэйгээ байхад, Боржигины бор тал, Хуримын зар, Хүүдээ унших шүлэг, Тэр нэгэн бүсгүйд, Би . Ижий мөрөн

### ABSTRACT

Cognitive metaphors, which are the result of elaborate acts of thinking that associate the mind, brain and external world, are shown by the poetic examples of Mongolian popular poet Lkhagvasuren Bavuu in the article.